



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/313

Хэрлэн сум

Үнэ бууруулж худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээ”-ний 2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар тогтоолыг, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 53,917,313 төгрөг 86 мөнгөний балансын үнэтэй, 24,712,102 төгрөг 14 мөнгөний хуримтлагдсан элэгдэлтэй, 29,205,211 төгрөг 72 мөнгөний үлдэх өртөгтэй 2 нэр төрлийн барилга байгууламж, Дадал сумын Засаг даргын Тамгын газрын 35,700,000 төгрөгийн балансын үнэтэй, 35,700,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, үлдэх өртөггүй 2 ширхэг автомашин зэргийг анхны дуудлага худалдааны үнээс 50 хувиар үнэ бууруулан худалдсугай.

2. Үнэ бууруулан худалдах эд хөрөнгийг хавсралтаар баталсугай.

3. Үнэ бууруулан худалдах хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлыг Батширээт, Дадал сумдын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Эрдэнэчимэг, Д.Гэрэлмаа) нарт даалгасугай.

4. Үнэ бууруулж худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2022 оны 6 дугаар сарын 30-ны 11:00 цагт Батширээт, Дадал сумдын Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулсугай.

5. Эд хөрөнгийг үнэ бууруулан худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010674



Аймгийн Засаг даргын 2022 оны  
дүгээр сарын 13-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

Үнэ бууруулан нээлттэй дуудлага худалдаагаар  
худалдах хөрөнгийн жагсаалт

д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ	хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Худалдах үнийн санал		
							Анхны санал	Бууруулах санал	АИТХ-ын шийдвэр
1	Батширээт сумын Ерөнхий боловсролын Сургууль	Баамын улаан байр	1985	39,376,886	18,047,739	21,329,146	21,330,000	10,665,000	10,665,000
2	Батширээт сумын Ерөнхий боловсролын Сургууль	Багш нарын байр	1979	14,540,427	6,664,362	7,876,064	7,900,000	3,950,000	3,950,000
3	Дадал ЗДТГ	Кама хогны машин ХЭҮ 2528	2012	16,200,000	16,200,000	0	5000 000	2,500,000	2,500,000
4	Дадал ЗДТГ	Pick up L200 ХЭҮ 40-71	2013	19,500,000	19,500,000	0	1,500,000	750,000	750,000
<b>Нийт дүн</b>				<b>89,617,313</b>	<b>60,412,101</b>	<b>29,205,210</b>			